



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 18,500,000.00 (арван найман сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Төрийн банк" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Гантөрд дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

13201106

D:\Huraldaanii material\2021 on\2021.02.04 3r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2021 оны 02  
дугаар сарын 04-ний өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

**"Төрийн банк" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй  
дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	УАЗ-31514 маркийн, 90-30 ГАА улсын дугаартай, /101005005/ арлын дугаар-А002626, суудлын автомашин	2010/2010	130000 км	18,500,000	1,500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			18,500,000.00 (арван найман сая таван зуун мянган)	1,500,000.00 (нэг сая таван зуун мянган)